

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-25

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./ 3-25

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
08 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 22 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Батжаргал, А.Ундраа.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын менежер Ч.Болд, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, И.Эрдэнэцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны ерөнхий нягтлан бодогч Л.Оюунчимэг, Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дэчин, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Цаг уур, орчны шинжилгээний газрын Санхүү төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Н.Галцог, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, “Биокомбинат” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал М.Энх-Амар, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Б.Алтансүх, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Хяналт

шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Сангийн сайд Б.Жавхлан нар танилцуулав.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх дүгнэлт болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Б.Уянга, Н.Наранбаатар, М.Ганхүлэг, М.Мандхай нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, 21 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 22 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж 61.9 хувьтай ирц бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 24 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн зүйлийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгосон тойрог, нэрээр танилцуулах ёстой.

Гишүүд Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн, Тилеуханы Аубакир ирсэн, одоо давхар хуралдаанд үг хэлж байна ирцэд орчихсон байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн 6 дугаар тойрог ирсэн, Сонгобайгийн Замира жагсаалтаар орсон гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог ирсэн, Мэндбаяр Мандухай гишүүн жагсаалт ирсэн, Цагаанхүүгийн Мөнхбат 7 дугаар тойрог орон нутагт ажиллаж байгаа. Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог ирсэн, Нанзадын Наранбаатар гишүүн 7 дугаар ирсэн, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн, Агваанлуvsангийн Ундраа өвчтэй, Болдын Уянгаа жагсаалтаар орсон гишүүн ирсэн байна. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 23 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр дахь асуудал энэ Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” байсан чинь Их Хурлын даргын захирамжаар байгуулагдах учраас энэ асуудлыг өнөөдөр хэлэлцэхгүй.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлыг баталлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 23 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна. Зарим Байнгын хороо давхцаж байгаа учраас зарим гишүүд ажлын хэсгийн гишүүд бас бусад Байнгын хорооны хурлуудаар байгаа учраас ирснийг нь танилцуулж байя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайд, Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Оюунхүү Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Идэрбалжинням Гүйцэтгэл-нийцлийн

аудитын газрын аудитор, Нямжаргал Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Ц.Болд Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, С.Бат-Эрдэнэ Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, И.Эрдэнэцэцэг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Төрийн нарийн бичгийн дарга, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн дарга юм байна. Г.Бат-Эрдэнэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Л.Идэрцогт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Оюунчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ерөнхий нягтлан бодогч, Д.Дэчин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б.Оюунсанаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга, Д.Сайханжаргал Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга, Н.Галцог Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын Санхүү төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Ц.Амгалан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч, М.Энх-Амар “Биокомбинат” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Б.Алтансүх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Я.Эрдэнэсайхан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Б.Цогтсаран Хөдөө аж ахуйн корпорац ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Б.Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга,

Л.Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл, төсвийн Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 онд 23 оны 3 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 22.5 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай төлөвлөгдсөнөөс 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын нийт 155 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүнд 501.8 тэрбум

төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 394.1 тэрбум төгрөг хөрөнгийн зардалд 91.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 27.5 хувь буюу 138 тэрбум төгрөгийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 72.5 хувь буюу 363.7 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын багц эцсийн зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 478.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 62 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 4 номер микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хуучнаар Байгаль орчин, аялал жсуулчлалын сайд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 92 санхүүгийн тайлан нэгтгэснээс 53 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 39 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 45 байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй, 8 байгууллагын санхүүгийн тайланд хязгаартай дүгнэлт өглөө.

Санхүүгийн аудитаар нийт 8.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 35 төлбөрийн акт тогтоож, 6.6 тэрбум 100 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 65 албан шаардлага, 0.5 тэрбум төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 1.7 тэрбум төгрөгийн зөрчилд 56 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 21.8 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 21.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 6.1

тэрбум төгрөгийн 59 зөрчил илэрснээс 5.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 21 албан шаардлага, 4 албан тушаалтанд хариуцлага тооцох 2 албан шаардлага хүргүүлж, 0.9 тэрбум төгрөгийн зөрчилд 36 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нийт 48.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 70 хувьтай байна.

2.Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн 64 санхүүгийн тайлан нэгтгэснээс 53 байгууллагын байгууллагад дүгнэлт гаргаж, 11 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 39 байгууллагад өөрчлөлтгүй, 13 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгч, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 326.2 тэрбум төгрөгийн 157 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 27 төлбөрийн акт тогтоож, 311.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 53 албан шаардлага, 14.3 тэрбум төгрөгийн зөрчилд 77 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 72.4 тэрбум төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 51.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 20.9 тэрбум төгрөгийн алдааг дахин давтахгүй, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 34.8

тэрбум төгрөгийн 72 зөрчил илэрснээс 33.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, 28 хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлж, 1.6 тэрбум төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 138.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 74.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй шилжин хэрэгжих 47 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Нийт төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэл 91 хувьтай, бүрэн хэрэгжиж дууссан 25, хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй 22 төсөл, арга хэмжээ байна.

Аудитын дүгнэлтэд үндэслэн цаашид анхаарах асуудлуудыг толилуулж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад.

Засгийн газрын 2015 оны 315 дугаар тогтоолыг баталсан. Татан буулгасан Аялал жуулчлалын үндэсний төв Засгийн газрын 2022 оны 243 дугаар тогтоолоор татан буулгасан. Монгол Улс төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, цэвэр ашигийн цэвэр хөрөнгийг шийдвэрлэж хаалтын баланс гаргах, урьдчилж гарсан зардал дансанд Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Цэвэр агаар сангаас 2012 онд олгосон нэр бүхий 9 байгууллагын 9.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийн олон жил болсон үлдэгдэлтэй үр дүнг хянаж шийдвэрлэх.

Дараагийн дугаарт, Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй Орчны бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээний хүрээнд 2019-2021 онд гүйцэтгэсэн аймгуудын ДЦС-д шүүлтүүр суурилуулах ажлын 3.1 тэрбум төгрөг, Аюултай хог хаягдлыг түр хадгалах,

агуулах барих ажлын 2.2 тэрбум төгрөг, лаг шатаах үйлдвэр барих 0.4 тэрбум төгрөг, төвийн дулааны шугам сүлжээний ажлын 2.9 тэрбум төгрөг, хийн халаагуур нийлүүлэх ажлын 0.7 тэрбум төгрөг, нийт 9.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг дуусаагүй асуудлыг шийдвэрлэх.

Дараагийн дугаарт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Сангийн яам Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хооронд байгуулсан дамжуулан зээлийн гэрээний 117.9 тэрбум төгрөг, санхүүгийн түрээсийн өр төлбөр барагдуулах гэрээний 31.8 тэрбум төгрөг, нийт 149.7 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон муу зээлийн ангилалд бүртгэлтэй 99.4 тэрбум төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах, Хөдөө аж ахуй корпорац төрийн өмчит хариуцлагатай компанийн авлагын дансанд бүртгэлтэй 107.4 тэрбум төгрөгийн тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах.

Дараагийн дугаарт, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Улсын комисс хүлээн авснаас хойш авсан 2.4 төгрөгийн 2.4 тэрбум төгрөгийн барилга байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэх. Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит хариуцлагатай компанийн санхүүгийн тайланд Хөдөө аж ахуйн үндэсний их сургуулийн Хөдөө аж ахуй, хүнс, үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 29 байгууллагуудаас авах хөдөө аж ахуйн бага оврын трактор, Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд жимсний суулгацыг дамжуулан олгосон зээлийн болон бусад дэмжлэгийн 6.6 тэрбум төгрөгийн авлага бүртгэлтэй боловч Аймгийн хөдөө аж ахуйн газрууд болон бусад харьяа газруудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэж өгөх.

Аудиттай холбоотой гүйцэтгэлийн танилцуулгыг хийж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Загджав даргад баярлалаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас төсвийн гүйцэтгэлд санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгье.

Мандухай гишүүн бас юм асууя гэсэн Мандухай гишүүнээр тасалъя.

Мэндсайхан гишүүн асуулт асууя.

З.Мэндсайхан: Энэ Хөдөө аж ахуйн яамныхан Хоршоо хөгжүүлэх сан гээд байгаа шүү дээ тийм ээ? Сум хөгжүүлэх сан гээд. Энэ Шинэ хоршоо, чинээлэг малчин хөтөлбөр гээд бид нар хоршооллын хөтөлбөр гаргаад яваад байгаа. Энэ хоёр маань ер нь яаж хоорондоо уялдаж байгаа юм бол? Энэ талаар хариулт өгөөч.

Төрийн өмчийн хорооныхон байвал энэ манай ТӨК-уд ер нь арилжааны банканд байгаа мөнгөний нийт 6 их наяд төгрөгийн чинь бараг 75 хувь нь төрийн өмчит, орон нутгийн компаниуд байна гэж байна.

Тэгэхээр энэ компаниуд маань, ТӨК-уд маань ингээд өөрсдөө арилжааны банкаар гүйлгээ хийгээд, төсөл, хөтөлбөрөө батлуулаад явдаг төрийн өмчийн өөрөө бизнес төлөвлөгөөг нь батлаад явдаг. Энэ яагаад ер нь цаашидаа Сангийн яамтайгаа уялдаад нэгдсэн төсөвтөө захирагдаад явдаггүй ийм бүртгэлдээ ордоггүй ийм мөнгө яваад байна? Ингээж өөрсдөө ТӨК-уд аж ахуйн үйл ажиллагаа эрхлээд, зөвхөн байгуулсан ноогдол ашгаа төрд тушаагаад явна гэдэг нь цаанаа ТӨК-уд чинь ТӨК дээр гараад байгаа тэр алдаа завхрал, авлигал, ашиг сонирхол гэдэг юм

чинь ерөөсөө л энэ байдалтай, төсвийн уялдаагүй байдалтай л холбоотой байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Төрийн өмчийн хороо ямар бодлого баримталж байна? Өнгөрсөн онд ТӨК-удын алдагдал ер нь хэд байв? ТӨК-удын бизнес төлөвлөгөөг Төрийн өмчийн хорооны 10-аад гишүүн сууж байгаад баталдаг энэ хэлбэр маань цаашаа яваад байх нь зөв үү? Энэ бүгдийн цаана улсын хэдэн их наядын хөрөнгө байгаа билээ? Энийг төрийн албан хаагч дээр очоод 1 өдөр хуралдаад бизнес төлөвлөгөөг нь батлаад явдаг энэ асуудлуудаа засаглалын хувьд ер нь ямар өөрчлөлт хийх гэж байна? Энэ дээр Төрийн өмчийн хороо хариулт өгөөч.

Байгаль орчны төлөөллөөс би юм асуучихъя. Тэр энэ төсвийн гүйцэтгэлтэй холбоогүйгээр, би олдсон дээр нь асуугаад авъя гэж бодож байна. Ховд аймгийн тэр Мянгат сумын Халзан бүргэдэйн төсөл гээд Уул уурхайн яам явуулна гээд шийдвэр гаргасан гээд өчигдөр би бас мэдээлэл авлаа. Тэгэхээр энэ тухайн үеийн байгаль орчны мэргэжлийн хяналтын байцаагч байгаль орчинд нөлөөлөх сөрөг дүгнэлт гарсан байна. Энэ лицензийг цуцлах ёстой юм гэсэн дүгнэлт гарсан. Одоо болтол хүчин төгөлдөр байдаг.

Тэгэхээр мэргэжлийн чиг үүргийн хяналтууд нөгөө салбар яамддаа очсон байгаа. Тэгэхээр энэ хүчин төгөлдөр актыг яагаад Байгаль орчны яам хэрэгжүүлэхгүй энэ асуудлыг өнөөдрийг болтол энэ хувийн хэвшилд давуу байдал олгоод тэр бүс нутагт амьдарч байгаа иргэд, хүн амьтан, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн ийм асуудлыг үүсгээд байна. Энэ дээр Байгаль орчны яам яагаад өнөөдрийг хүртэл дуугүй байгаад байна. Энэ дээр хариулт өгөөдхөөч.

Б.Бейсен: Эхлээд тэр юуны Төрийн өмчийнхөн хариул. Хөдөө аж ахуйнхан хариулах юм уу? Хэдэн номер вэ? 4 номер.

Я.Эрдэнэсайхан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Эрдэнэсайхан.

Хоршоо хөгжүүлэх санг өмнө нь Сум хөгжүүлэх сан байсныг 2021 онд Хоршоо хөгжүүлэх сан болгосон. Тухайн үедээ энэ сангийн бас эргэн төлөлтийн чанар бол маш муу байсан. 79 хувьтай байсан. Энийг Хоршоо хөгжүүлэх сан болгож өөрчлөөд журмыг нь шинэчилсэн. Дээрээс нь Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүх мэдээллийг нийлүүлдэг болсон. Өнөөдрийн байдлаар shilengov.mn-д бас нийлүүлээд мэдээллийг нь ил тод болгоод явж байна. Аймаг, сумын удирдлагуудад албан бичгүүдийг хүргүүлж, энэ сан өөрөө Монгол Улсын 330 сумд сумын Засаг даргын байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийж олгодог ийм сан байгаа. Ингээд сангийн үйл ажиллагаа бол нэлээд жигдрээд явж байгаа.

Шинэ хоршоо хөдөлгөөнийг бүгд мэдэж байгаа. Энэ дээр 2025 онд улсын төсөв дээр 50 тэрбум төгрөгийг энэ Хоршоо хөгжүүлэх санд олгох ийм саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүргүүлээд байгаа. Арилжааны банкны эх үүсвэрээр олгогдож байгаа эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн хүүгийн хөнгөлөлтөд бол 500 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор 25 оны төсөв дээр явж байгаа. Үүний хүүгийн зөрүү 24 онд олгосон болон 25 онд олгох хүүгийн зөрүүг бол улсын төсвөөс олгох ийм санал хүргэгдээд байгаа. Энэ Хоршоо хөгжүүлэх сан, Шинэ хоршоо хөдөлгөөн хоорондоо нягт уялдаатай явна. Баярлалаа.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Эрдэнэсайхан тэр Шинэ хоршоо хөдөлгөөн, энэ Хоршооны сан хоёр байна шүү дээ энэ хоёрын чинь чиг үүрэг ер нь яг адилхан байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэний чинь энэ сан

чинь ер нь цаашидаа хэрэгтэй юм уу? Одоо нэгэнт ингээд бид нар Шинэ хоршоо хөдөлгөөн гээд улс орон даяар хоршооллын л хөдөлгөөн байгуулаад явж байгаа шүү дээ. Тэгээд арилжааны банкаар бид нар зээлийн хүүгийн татаасыг нь өгөөд явуулчихна.

Тэгэхээр цаана нь ахиад бид нар ийм сан байгуулаад яваад байх шаардлага байна уу? Энэ чинь нэг чиг үүрэгтэй, нэг зорилготой хоёр юу л болчихоод байна шүү дээ хөтөлбөр. Тэгэхээр энэ дээр энэ хоёрыг нэгтгэдэг юм уу? Энэ санг цааш нь өөрчлөн байгуулах ийм бодлого байна уу?

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Сум хөгжүүлэх сан ба энэ Хоршоо хөгжүүлэх сан болохдоо өмнө Сум хөгжүүлэх сан байхдаа энэ улсын төсвөөс мөнгөнүүд тавигдаад эх үүсвэр нь аль хэдийн бүрдчихсэн тэрийгээ эргэн төлөлтөөсөө бүрдүүлээд дахиад олгох замаар явж байгаа ийм мөнгөн сан байгаа.

Хоршоо хөгжүүлэх сангаас олгож байгаа санхүүжилт бол арилжааны банкны эх үүсвэрийг б-аас нэмэх, цаадах хүүгийн зөрүүг нь улсын төсөв дээр хүүгийн хөнгөлөлт байдлаар тусгаад ингээд олгоод явж байгаа. Тэгэхээр энэ хоёр хоорондоо зорилго нь нэгдчихсэн хоёр тал болж бие биеэ дэмжиж явж байгаа.

Б.Бейсен: Байгаль орчны яам хариулъя. 3 номер.

Э.Баттулга: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Ховд аймгийн Мянгад сумын Халзан бүргэдэйн ордын талаар энэ байгаль орчны байцаагчийн гаргасан дүгнэлтийн мэдээлэл бол яг одоогоор байхгүй байна. Хувийн хэвшилд давуу байдал олгосон асуудал байвал энэ асуудлыг нягтлаад гишүүнд дэлгэрэнгүй тайлбар, мэдээллийг өгье. Баярлалаа.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Энэ Төрийн нарийнаа ийм байгаа юм, наадах чинь яг тэр үеийн улсын байцаагчийн дүгнэлт нь гараад байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэхгүй бол энэ тухайн бүс нутаг болон иргэд, хүн амьтны амьдрах тайван нөхцөл, мал амьтны, тэгээд тэр бүс нутгийн экологийн байдалд ноцтой хувирал учруулах юм байна гэдэг дүгнэлт нь гарчихсан байгаа юм. Тэгээд энийг ерөөсөө хэрэгжүүлэх гээд яваад байгаа юм. Тэгэхээр та энэ байцаагчийн дүгнэлтийг би өнөөдөр бас Уул уурхайн сайдад асуулга тавьж байна. Энэ байцаалтыг мэргэжлийн байгууллагын ахлах байцаагчийн тавьсан дүгнэлт өнөөдөр хэрэгжихгүй юм бол бид нар төрийн захиргааны байгууллага гаргасан акт шийдвэрээ хэрэгжүүлэхгүй байгааг л би асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүгд маш тодорхой хариултыг надад өгөөрэй гэдгийг хэлэх байна. Та мэдээлэлгүй байгаа юм шиг байна одоо.

Б.Бейсен: 3 номер хариулъя. Тодорхой юм асууж байна шүү дээ. Тодорхой хариулж өгөөрэй. Дүгнэлт нь гарчихсан гээд байна. Та нар гаараагүй гэж тэгж байна.

Э.Баттулга: Ойлголоо гишүүний тавьсан асуудлыг ойлголоо. Бид нар тухайн үед Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын байцаагчийн гаргасан дүгнэлттэй холбогдуулаад одоо бол манай салбарын хяналтын газар болоод нэгтгэгдээд ирчихсэн байгаа. Тухайн үед гаргасан дүгнэлтийг нь нягталж үзээд эргээд гишүүнд ажил хэргийн шугамаар тайлбарыг нь өгье гишүүнээ.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн төрийн өмчтэй холбоотойгоор Төрийн өмчийнхөн ирсэн үү? Өөр Байнгын хороонд, Сангийн сайд хариулах юм уу? Мэндсайхан сайд төрийн өмчтэй холбоотой. Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Тэр төрийн өмчийн ер нь бол Сангийн яам 2011 оноос хойш Төрийн сангийн Төрийн сан банк ч гэж нэрлэж байсан үе байгаа. Төрийн сангийн нэгдсэн дансны зохион байгуулалтад орсноор төсвийн байгууллагуудын төрийн сангаас гадуур байгаа олон тийм эх үүсвэрүүдийг бүгдийг нь нэгтгэж удирддаг болоод нэлээн удаж байгаа. Энэ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн ч бай эдгээрүүд дээр энэ дансны тийм нэгдсэн зохион байгуулалт одоогоор бол байхгүй. Энэ дээр энэ Хэрэг эрхлэх газраас л Хэрэг эрхлэх газар Төрийн өмчийн боловсруулалтын газраас илүү мэдээлэл өгвөл их зүгээр байх даа. Манай дээр энэ талаар ямар нэг бодлого бол байхгүй байна.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ аудитын газрынхнаас нэг зүйл тодруулах гэсэн юм. Энэ өнгөрсөн 2023 оны төсвийн гүйцэтгэл орж ирж байх шиг байна. Энэ дээр Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл хийсэн аудитын тайлан гээд нэлээн том тайлан орж ирж байх шиг байна. Энэ дээр та бүхэн маань нийт төсөл, хөтөлбөрүүд, улсын төсөвт суусан төсөл, хөтөлбөрүүдийн тэд нь жинхэнэ юу гэдэг юм төсөл, хөтөлбөрүүд нь яг бодлогын хүрээнд бол зөв бодлогоор суусан хөтөлбөрүүд байна. Зарим нь техник, эдийн засгийн үндэслэлгүй эд нар юмнууд, зураг, төсөлгүй эд нар юмнууд орж ирсэн байдаг юм. Тэгээд яг ийм бодлогын алдаанууд ер нь хэр гарч ирж байна? Та бүхнээс яг энэ гүйцэтгэлийн аудит дээр хийсэн дүгнэлт бас байна уу, үгүй юү? Нэг.

Хоёрдугаарт, Жавхлан сайдаас нэг зүйл тодруулъя. Шинэ хөдөө хөтөлбөр дээр болохоор та бас нэг зүйл хэлдэг шүү дээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмжийн асуудлууд жоохон цалгардаад байна

гэдэг байх тээ? Өмчлөлийн хэлбэр нь арай ондоо байна гээд. Жишээ нь, Булганы хүрээнд бол эндээс суусан, улсын төсвөөс суусан тоног төхөөрөмж, хөрөнгүүд нь орон нутагтаа шилжээд, орон нутаг нь шийдвэрээ гаргаад орон нутгийн өмчит компанидаа шилжүүлээд, захиран зарцуулах, хянах зүйлүүдээ тэндээ хийгээд тэндээ тэндээсээ тоног төхөөрөмжүүдээ түрээслээд ингээд ямар ч байсан орон нутгийн хяналтад оччихож байгаа юм.

Тэгэхээр одоо энэ сүүлийн 10 гаран аймаг дээр хийгдэж байгаа шинэ хөдөө хөтөлбөрүүд дээр ер нь ямаршуу явж байна вэ? Энэ дээр сайн дүгнэлт хийж бид нар үзэхгүй бол энэ хөтөлбөр маань цаашидаа буруу тийшээгээ бүр ингээд халбийгаад явчих вий дээ л гэж бас бодоод байгаа юм л даа. Энэ дээр ямар дүгнэлт байна? Аудитынхан энэ дээр бас хийсэн дүгнэлт байна уу, үгүй юү? Үзсэн харсан зүйл байна уу? Хөдөө аж ахуйн яамныхан яг юу гэж харж байгаа? Энийг цаашидаа ер нь яаж засаж, залаад явах нь зүйтэй, ер нь зөв зүйтэй хөтөлбөр байна уу, буруу хөтөлбөр байна уу гээд энэ тал дээр нь Хөдөө аж ахуйн яам, Аудитынхан, Сангийн сайд бас хариулт хэлээч. Баярлалаа.

Б.Бейсен: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тийм өмнө нь анх Бат-Эрдэнэ гишүүн энэ асуудлуудыг санаачлаад ингээд явж байхад эхлээд нэлээн үр дүнтэй эхний жилүүдэд явсан. Тэгээд би сүүлд нь харахад тийм үр дүнгүүд гарсан байна лээ. Харин сүүлийн үед жоохон буруу тийшээ яваад байна. Тэрнээс болоод ер нь энэ Шинэ хөдөө төсөл маань цаашаа ер нь явахгүй болчих вий гэдэг бас их болгоомжлол байна шүү. Улам л жижгэрээд байгаа юм. Авч өгдөг худалдан авалт хийдэг, тэр төрийн өмчийн болон орон нутгийн өмчид очиж бүртгэхдээ за даа ер нь зарим

гүйцэтгэлүүдийг нь харахад яг тэр компани дээрээ, орон нутаг дээрээ очилгүй шууд иргэдийн гар дээр очдог тийм бага үнэтэй, түргэн элэгддэг болон сүүлдээ оёдлын машин, жижиг өөр ийм янз янзын л юм болсон. Янз янзын л юм болно лээ. Тийм.

Тийм учраас уг нь бол энэ чинь төсвийн I төгрөг болгон худалдан авалт хийгээд хөрөнгө болж байгаа бол тэр нь цаашаагаа эзэмшигч нь мөн төрийн байгууллага байх ёстой. Төрийн өмчит бүртгэлтэй тэгээд цаашаа явах ёстой юм байгаа юм.

Гэтэл тэр нь зарим нь нэр төдий бүртгэсэн нэртэй, тэгээд шууд иргэдийн хэрэгцээнд аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээнд очоод тэгээд эргээд нөгөө хөрөнгийн хяналт энэ юмнууд нь маш сул иймэрхүү л болж ирээд байгаа. Тэгээд цаашидаа ер нь л их л хумигдмал болоод л байна лээ. Тийм анхны зорилгоосоо нэлээн хазайгаад холдоод яваад байгаа тийм тал байна.

Б.Бейсен: Аудитынхан саяын асуултад хариул 4 номер.

Ц.Наранчимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих 1139 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн. Аудитын байгууллага төсвийн гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэлд тусгайлан аудитыг хийсэн байгаа. Үүнд 552 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, боловсрол, спортын 209, эмнэлгийн 49, барилга, цэвэр, бохир усны шугамын хоолой 345км, дулааны 70.4км шугам, цахилгаан дамжуулах агаарын 71.4км, авто замын 74.6км, гүүр 598.2 урт метртэй гүүр их засварын 44 ажил ашиглалтад орсон гэж аудитын хөрөнгө оруулалтуудын аудитаар дүгнэсэн. Ер нь хойшид энэ төсөл.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя. Минут нэмье.

Ц.Наранчимэг: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулж төлөвлөхгүй байгаа зэрэг нь төсөл, арга хэмжээг удааширах, төсөвт өртөг нэмэгдэх гол шалтгаан болж байна гэсэн ийм дүгнэлтийг өгсөн байгаа.

Хоёр дахь асуулт нь Шинэ хөдөө хоршоотой холбогдуулаад төрийн аудитын байгууллага босоо тогтолцоотой орон нутаг дахь аймгуудад дахь төрийн аудитын газрууд маань аудит хийж байгаа. Энэ дээр бас нэлээдгүй эрсдэл байна гэж ингэж аудитаар дүгнэлтүүд гарч байгаа.

Булган аймаг дахь Шинэ хоршоод Булган аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийгээд сөрөг дүгнэлтийг өгсөн байгаа.

Хөдөө аж ахуйн яамныхан хариулъя. 5 номер.

Т.Жамбалцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. 2023 оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсөв дээр 11 арга хэмжээ 26.2 тэрбум төгрөгийн Шинэ хөдөө төслүүд тусгагдсан. Тэгээд Шинэ хөдөө төслүүд бас харилцан адилгүй. Зарим үйл ажиллагаа салбарын бодлого үйл ажиллагаатай уялдаад маш сайн хэрэгжиж байгаа. Шинэ хөдөө жишиг төслүүд бас байгаа. Салбарын бодлого үйл ажиллагаатай уялдахгүй, салбарын сайдын багц дээр Шинэ хөдөө төсөл нэрээр тоног төхөөрөмж, бараа материал тавьж худалдан авч, тэрийгээ аймаг, орон нутгийн өмч рүү шилжүүлээд, эргээд тэрийгээ иргэн, аж ахуйн нэгжид гэрээгээр ашиглуулна гээд яг энэ хөрөнгийг бүртгэхэд төвөгтэй асуудал үүсдэг. Сая яг түрүүний Жавхлан сайдын хэлдэг ийм асуудлууд үүсдэг юм. Тэгээд үндсэндээ юу гэдэг юм 24 он дээр энэ Шинэ хөдөө арга хэмжээ бас нэлээд хувь хэмжээгээр нэмэгдсэн. Одоо 25 оны төсөв дээр харьцангуй бага

орж ирсэн. Тэгэхээр энэ үндсэн Засгийн газрын үйл ажиллагааны.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулъя, 5 номер.

Т.Жамбалцэрэн: Төрөөс баримталж байгаа бодлого ишидвэрүүдтэй уялдаад хэрэгжих юм бол үр дүнтэй салбарын төсвийг дэмжсэн, салбарын хөрөнгө оруулалтыг дэмжсэн сайн үйл ажиллагаа болж байгаа юм. Энэ нэрээр далимдуулаад дахиад энэ төсвийн хөрөнгийг үрэгдүүлэх, бараа материал, тоног төхөөрөмж болгоод зарим тохиолдолд тодорхой жишээ байгаа байхгүй юу. Компьютер, таблет болгоод багш нарт тараасан хүртэл асуудал байдаг.

Тэгэхээр ийм асуудлууд цаашидаа гармааргүй байгаа юм. Яг түрүүний Жавхлан сайдын хэлдэг оёдлын машин, жижиг, дунд үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж гээд эргээд нөгөө эцсийн хөрөнгийг нь бүртгэх нөгөөдхийг нь хяналт тавих боломжгүй иргэн, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр ашиглуулчихдаг, эргээд нөгөөдхийг нь бүртгэж хяналт тавих боломжгүй ийм нөхцөл байдлууд бас бүрддэг талууд байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Солонгост хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж түрээсэлдэг ийм компани байдаг юм. Бүүр тосгон болгонд нь байдаг юм шүү. Тэгээд бид бодохдоо бол энэ Солонгосын тариаланчид жимс ногоо юу тарьдаг юм тариаланчид бол хөл дээрээ босоцгоосон, бүгдээрээ тоног төхөөрөмжтэй, гайхалтай мундаг баян тийм компани, иргэд байдаг байх гэж боддог.

Гэтэл яг амьдрал дээрээ очиход бол тосгон болгонд нь түрээсийн ийм компани байгаа шүү дээ. Тэгээд ерөөсөө

тэндээсээ аваад өдрөөр ч, цагаар ч, сараар ч түрээслээд ингээд явчихдаг. Трактор бүх л юмнуудаараа аваад ингээд үйл ажиллагаандаа хавар, намар, ямар цагт байдаг юм тэр л хэрэгцээтэй цагтаа бол түрээсэлж явдаг ийм компани байдаг юм.

Хөгжсөн энэ Солонгос улс чинь түрээсийн үйл ажиллагаа явуулаад ард иргэдээ ингээд халамжлаад, хөгжүүлээд явж байгаа юм. Бид болохоор энэ дээр ямар ч тийм асуудал байхгүй зүгээр гар татаад л байгаа байхгүй юу даа. Энд Хөдөө аж ахуйн яам ер нь ямар бодлоготой байдаг юм бэ? Зөв юм уу, буруу юм уу? Ийм байж цаашаа явах боломж бий юу?

Б.Бейсен: 5 Номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн салбар дээр энэ чиглэлээр тодорхой үйл ажиллагаанууд өмнөх жилүүдэд хийгдэж байсан. Ялангуяа техникээр үйлчлэх дундын төвүүдийг байгуулж ажиллаж байсан. Тоног төхөөрөмжийг аж ахуйн нэгжүүдийг жижиг, дунд үйлдвэрлэгчдийг бойжих төвүүдийг байгуулагдаж байсан, тоног төхөөрөмжийг урт хугацааны түрээс санхүүгийн түрээсээр лизингээр олгож байсан тохиолдлууд бий. Сүүлийн жилүүдэд энэ Шинэ хөдөө хөтөлбөрийн хүрэн дээр хийгдэж байгаа тоног төхөөрөмжүүд сайн жишгүүд бол байгаа. Ялангуяа юу гэдэг юм Хөдөө аж ахуйн корпорацитай хамтраад хийж байгаа, Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтраад хийж байгаа хөрөнгийг нь төр дээрээ бүртгүүлээд иргэн, аж ахуйн нэгжид Төрийн өмчийн хорооноос баталсан дүрэм, журмынх нь дагуу иргэн, аж ахуйн нэгж гэрээгээр ашиглуулаад үр дүнг нь тооцоод эргээд дараа дараагийн иргэн аж ахуйн нэгжүүд нь боломжийг нь олгоод энэ ажлууд хэвийн явагдаж байгаа.

Тэр арга хэмжээг тооцож болохгүйгээр бараа материалууд авдаг, орон нут

нутагтаа шилжүүлдэг, эргээд орон нутгийнхаа засаглал гэдэг юм уу тухайн.../минут дуусав./

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя. Аудитын газраас.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр Булган аймгийн аудитын газар Шинэ хөдөө хөтөлбөрийг бол бүүр “нойл” гэж үзэж байгаа юм. Энд улс төрийн бас жоохон асуудал байгаад байгаа юм. “Нойл, Бат-Эрдэнийн санаачилсан Шинэ хөдөө хөтөлбөр бол нойл”, ямар ч хэрэгцээгүй гэж үзээд байгаа юм шүү.

Яагаад ингэж үзээд байгаа юм гэхээр ерөөсөө л миний саяын хэлсэн хүнд ямар нэгэн байдлаар орлого олох боломж, бололцоог хангасан энэ зүйлийг л хүлээн зөвшөөрөхгүй байгаа байхгүй юу. Яагаад гэхээр ашиг олохгүй байна гээд байгаа юм. Ашиг олохгүй байна, ашигтай ажиллах ёстой, тэр ард иргэдээ мөлжих ёстой гээд байгаа юм. Ард иргэдээсээ мөнгө олох ёстой гээд байгаа байхгүй юу. Миний хүсээд байгаа зүйл болохоор ард иргэдэд тусалъя, ард иргэдээ хөнгөхөн түрээсийн тоног төхөөрөмжөөр тусалъя, хөл дээрээ босох аж ахуйн нэгж, иргэд нь хөл дээрээ босох боломж бололцоог нь хангая гэдэг ийм миний бодлоор энэ Шинэ хөдөө явж байдаг. Та бүхний тэр аудитынхан болохоор ашиг олсонгүй, тэр ард иргэдээ юу гэдэг билээ мөлжсөнгүй гээд үзээд байгаа байхгүй юу. Энийг зөв юм уу, буруу юм уу? Та бүхэн сая хэллээ шүү дээ “нойл” ажиллаж байгаа.../минут дуусав./

Б.Бейсен: 4 номер хариулъя Аудитынхан.

Ц.Наранчимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар Шинэ хөдөө хоршоонд аудит хийгээд сөрөг дүгнэлт өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар

зүйлд сөрөг дүгнэлт авсан бол тухайн төсөв захирагчид хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлдэг.

Гэхдээ тус хоршооны захиран зарцуулж байгаа удирдлагын зүгээс энэ аудитын дүгнэлттэй санал нийлэхгүй байна гэсэн гомдлыг Төрийн аудитын байгууллагад гаргасан байгаа. Бид энэ дээр, энэ гомдлыг бас тусгай баг гаргаж энэ гомдол дээр манай аудитын байгууллага ажиллаж байгаа.

Бид шинэ хоршоон дээр Хүнс, хөдөө аж ахуйн яаманд бас албан шаардлага өгсөн. Энийг аудитын байгууллага юу гэж харж байна вэ гэхээр энийг хэрэгтэй зүйлд нь эдийн засгийн үр ашгаа өгөх зүйлд зарцуулах шаардлагатай гэдэг ийм зарцуулах дээр анхаарч ажиллах талаар Хүнс, хөдөө аж ахуйн яаманд албан шаардлага хүргэсэн.

Б.Бейсен: Дууссан. Уянга гишүүн асуулт асууя. Уянга гишүүн.

Б.Уянга: Байгаль орчин, аялал жуулчлалын яамныхнаасаа асууя. Усны нөөц, нуур, гол мөрний менежмент дээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 2023 онд 1.1 тэрбум, ус цаг, уур орчны шинжилгээн дээр ус, цаг уурын судалгаа, шинжилгээ дээр 1.6, ер нь эрдэм, шинжилгээ дээр манай Байгаль орчны яаман дээр тавигдаж байгаа мөнгөний хэмжээ 23 онд ийм байсан юм байна. 24 онд, 25 онд ер нь өсөж байгаа юу? Шинжлэх ухааны академитай хэрхэн хамтарч ажилладаг вэ? Яг энэ эрдэм шинжилгээ, судалгааныхаа ажлуудыг тендер зарлаж ямар нэгэн баг хамт олноор гүйцэтгэдэг үү? Мэдээж маш чухал үр дүнгүүд гарч байх ёстой. Тэгэхээр үе үе хийгдсэн энэ судалгаануудынх нь үр дүнг нь хаанаас авч болдог вэ, нийтлэгддэг үү? Хэрвээ нийтлэгддэггүй бол нийтлэх хэрэгтэй. Нийтэлдэг бол бас яаж, хаанаас олж авах мэдээллийг нь бас авмаар байна?

Б.Бейсен: 3 номер хариулъя.

Э.Баттулга: Уянга гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцад усны нөөц, нуур, гол мөрний менежментийн зардал, ус, цаг уур, орчны шинжилгээний зардал гээд хоёр тусдаа зардал сууж байгаа.

Ус, цаг уур, орчны шинжилгээний зардал бол Цаг уур, орчны шинжилгээний газар болоод тэрний харьяа орон нутаг дахь болон судалгааны хүрээлэн байгууллагуудын нийт зардал байдаг.

Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн зардал бол яг хөтөлбөрийн зардал болоод таны хэлж байгаа асуудлуудад зарцуулагдаад явдаг байгаа. 2023 онд 1.1 тэрбумаар батлагдсан бол 2024 онд 9.3 тэрбум болж нэмэгдсэн байгаа. Энэ жил ч гэсэн ер нь усны, геологийн, гидрогеологийн хайгуул судалгаа, усны гүний усны нөөцийн судалгаан дээр бол бас нэлээн өндөр ач холбогдол өгөөд явж байгаа. Энэ жил бас 25 оны төсвийн тодотголд бол бид нар энэ дээр нэлээн олон асуудлууд тусгаад оруулсан.

Одоогийн байдлаар гидрогеологийн дунд маситабын зураглал хийгдсэн нутаг дэвсгэрийн хэмжээ 17.3 байгаа. Ирэх жилүүдэд бол 20 орчимд хүргэх ийм зорилттой байна. Энэ дээр хийгдэж байгаа судалгааны ажлууд дээр бол их төлөв Шинжлэх ухааны академийн Гео-экологийн хүрээлэнтэй хамтарч ажиллаж байгаа. Манай Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяанд бас Цаг уур, орчны шинжилгээний хүрээлэн ажилладаг. Хүрээлэн маань бас оролцоод явдаг. Энэ тайлан мэдээллүүд нь бол нийтэд мэдээлэх боломжтой мэдээллүүд нь И Ай Си цэг мн гээд Байгаль орчны тухай хуулиар үйл ажиллагааг нь зохицуулдаг байгаль орчны нэгдсэн мэдээллийн сан дээр байгаа. Энэ дээрээс бол тайлангуудыг хүлээж авах боломжтой байна. Баярлалаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 20-24 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас томоохон ажил, арга хэмжээ, төслүүд суугдсан. Танай хоёр яамтай холбоотой миний л мэдэхийн хоёр том төсөл олигтой яваагүй. Хөдөө аж ахуйн яамтай холбоотой тэр арьс ширний үйлдвэр барих, тэр хаягдаад байгаа түүхий эдээ боловсруулдаг, барьдаг, үнэ цэнд оруулдаг, цаашилбал гадагш нь экспортолдог барина гээд л том зорилт тавьсан. Хэрэгжсэн юм юу ч байхгүй. Одоо тэгээд л жалгын нэг хаягддаг хэвээрээ л явж байгаа юм.

Нөгөө Байгаль орчны яамны хийх ажилд, мөрийн хөтөлбөрт цөлжилтийг бууруулна, гадаргын усыг хуримтлуулна, түүнийгээ хөдөө аж ахуй, газар тариаланд хэрэглэнэ, мөн говь руу ус татах том төсөл суусан Хөх морь гээд л. Тэгээд энэ ажил бас л хэрэгжээгүй. Тэгээд ерөөсөө миний санаж байгаа хамгийн захын хоёр төслийг аваад үзэхэд л хэрэгжсэн юм байхгүй. Тэгээд юунаас болоод энэ хэрэгжихгүй байдаг юм? Энэ сая бид хэд ер нь баталчихлаа ирэх 4 жилийн хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр. Тэгэхээр энэ хоёр асуудал бас л суучих байх.

Цаашидаа энийг хэрэгжүүлэхэд ямар ажлууд хийх ёстой юм? Тухайлбал, тэр гадаргын усны төслийг Байгаль орчны яам хариуцах юм уу, аль эсвэл Хэрэг эрхлэх хариуцах юм уу? “Эрдэс Тавантолгой” хариуцаж цаашаа явах гээд байгаа юм уу? Хөрөнгө төсвийг нь яаж олох юм, өнгөрсөн хугацаанд хийсэн ямар ажил байгаа юм, гүйцэтгэл нь ямар гүйцэтгэлтэй байгаа юм гэсэн ийм хоёр асуудал дээр хоёр яам хэрэгжээгүй үндсэн шалтгаан, тэгээд цаашидаа яаж хэрэгжүүлэх юм гэдэг бодож төлөвлөж байгаа зорилтуудаа хэлээдхээч гэж.

Дараа нь энэ Шинэ хоршоо хөдөлгөөний үр дүн ямар байна? Хэчнээн

хэмжээний зээл олгож вэ? Одоо хэр нь л гишүүд дээр лав л над дээр мессеж малчдаас ирээд байгаа юугаа өгөхгүй байна шүү, зээлээ банкин дээр очоод зогсчихсон байна шүү зээл олголт гээд байгаа. Үнэхээр үр дүнтэй байгаа юм уу, үр дүнгүй байгаа юм уу? Үр дүнгүй ингээд баахан хөрөнгө төсөв цацах гэж байгаа бол эрт зогсоосон нь дээр. Чуулган дээр бас зарим гишүүд хэлж л байна лээ энэ зээл чинь ер нь малчид өр ширэнд ороод балрах юм биш үү гээд. Авсан мөнгөөрөө ерөөсөө баахан приус аваад Улаанбаатарын түгжээн дээр нэмчихлээ шүү ч гэж байх шиг янз бүрийн л асуудлууд яригдаад байх юм. Үнэхээр үр дүнтэй цаашаа явах юм уу, явахгүй юм уу, цаашаа зээл нь олгогдох юм уу, үгүй юм уу? Олон малчид бизнес эрхэлж байгаа хүмүүс бас энийг чинь хараад ингээд байж байгаа юм шүү гэсэн асуулт байна. Тэгээд тодруулъя.

Б.Бейсен: 3 номер Байгаль орчны яамныхан хариулъя.

Э.Баттулга: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцад газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх энэ зардалд 877 сая төгрөг төсөвлөгддөг. 877 сая төгрөг төсөвлөгддөг. Бид нар энэ говь руу ус татах, энэ говь цөлийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, гадаргын ус хуримтлуулах гэх мэтчилэн эдгээр ажлууд дээр бол энэ батлагдсан төсвүүдээс гол төлөв бүх аймаг, орон нутаг бүгдээрээ ашиглах боломжтой нэг хэв, загварын зураг хийх, стандарт шаардлагууд, техникийн тодорхойлолт боловсруулах гэх мэтчилэн ийм нийтлэг хэрэглээний ажлуудыг нь бол төсвөөс санхүүжүүлээд явж байгаа.

Учир юу вэ гэхээр энэ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу усны төлбөрөөс орсон орлогын 35 хувь нь орон нутгийн төсөвтөө буцаад ордог. Тэгээд энэ хуулийнхаа зохицуулалтаар бол буцаагаад усны нөөцийг хамгаалах,

бүрдүүлэх энэ чиглэлд нь зарцуулах ёстой.

2024 оны байдлаар жишигээр, уснаас 45-46 тэрбум төгрөг улсын төсөвт орсон байдаг. Буцаагаад эргэн зарцуулалт 60 хүрэхгүй хувьтай байгаад байдаг. Тэгэхээр орон нутаг маань энэ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс, хур тунадасны горим өөрчлөгдөж байгаагаас болж жил ирэх тусам багасаж байгаа энэ хур тунадасныхаа хэмжээг гадаргын усаа хуримтлуулаад, үерийн усыг хуримтлуулаад ингээд шийдэх боломжтой гэж үзэж байгаа учраас энэ чиглэлээрээ төсөв хөрөнгөө тавиад яв гэсэн ийм чиглэлийг, зөвлөмжүүдийг байнга хүргүүлж байгаа.

Энэ таны хэлж байгаа тэр гол гол төслүүд дээр бол бид нар юу байна. Хэрлэн-Тооно, Орхон-Онги гэх мэтчилэн энэ усны мега төслүүдийн хувьд бол энэ жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бол өчигдөр батлагдсан төсөвт бол яг энэ нэр томъёоллоороо суусан байгаа. Гол ажлууд нь бол жишигээр, Хэрлэн-Тооно төслийн хувьд бол “Оюутолгой” компанийн санхүүжилтээр “Эрдэнэс Оюутолгой” компани ТЭЗҮ-г нь зарлаад 8 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Тендерийн төсөвт өртөг 10.1 тэрбум төгрөгийн өртөгтэй байгаа. Бусдыг нь бол бид нар ингэж харж байгаа. Хамгийн гол бодлогын хувьд чиглэх ажлууд эхлээд ерөөсөө гүний усныхаа нөөцийг тодорхойлоодохъё. Түрүүн Уянгаа гишүүний хэлдэг тэр гидрогеологийн дунд масштабын зураглал хийх, газрын гүний усны нөөцийн судалгаагаа ондоо их өндөр ач холбогдол өгч төсөв тавиарай гэдэг дээрээ л бид нар бүх ирэх жилүүдийнхээ төсвийг тавиад анхаарал хандуулаад явна гэж ойлгож байна.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн яамныхан хариулъя, 5 номер.

Т.Жамбалцэрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ

цэнийг өсөн нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тодорхой ажлуудыг зохион байгуулсан.

Нөгөө олонд их хүлээлттэй байгаад байдаг Дарханы арьс ширний цогцолбор маань хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, орон нутагтай хамтарсан компани байгуулаад ажиллаж байсан. Энэ маань өөрөө бас хууль, шүүхийн маргаантай болоод энэ төсөл гацсан. Энэ төсөлтэй төр хамтраад энэ өмнө нь хийгдсэн дэд бүтцийн ажлыг нь аваад шилжүүлээд ажиллаад явъя гэсэн боловч хууль, шүүхийн маргаан нь эцэслэгдээгүй учраас бид нар энийг үргэлжлүүлээд явах бололцоогүй болсон.

Энэнтэй холбоотой ТӨК байгуулаад Дархан-Уул аймагт тодорхой бас шинэ газар, бүсийг, байрилыг гаргаж байгаа ТЭЗҮ, холбогдох зураг төсвийн ажлыг хийгээд явж байгаа.

Шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг зохион байгуулах, дээр нь хөнгөн үйлдвэрийн.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Парк байгуулах ажлын хүрээнд энэ ажлууд үргэлжлээд хийгдээд явна. Мөн Говьсүмбэр аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн парк Шинжлэх ухааны төвтэйгөө байгуулагдахаар ингээд хувийн хэвчлүүд ажиллаж байгаа.

Дээр нь Өвөрхангай аймагт арьс шир, ноосны боловсруулах үйлдвэрлэл Засгийн газрын олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд ашиглалтад ороод үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа.

Баруун бүсэд Ховд аймагт хөнгөн үйлдвэрлэлийн Үйлдвэр, технологийн паркийн ажил хийгдэж байгаа. Улсын төсвийн санхүүжилттэй. Энэ онд дэд бүтцийн ажил 100 хувь гүйцээчих болов уу гэсэн ийм төсөөлөлтэй. Төсөв нь он дамжаад ингээд санхүүж ийм нөхцөл байдалтай байгаа.

Шинэ хоршоо, чинээлэг малчин хөдөлгөөний хүрээнд жилдээ 500 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банкны эх үүсвэрээр хоршооны зээлийг олгож байгаа. Энэ хүрээнд өнөөдрийн байдлаар өчигдөр 26-ны авсан сүүлийн мэдээ Монголбанкнаас авсан мэдээгээр.../минут дуусав./

Б.Бейсен: 5 номерт гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: 495.3 тэрбум төгрөгийн зээлийг 3467 хоршоонд олгосон байна. 500 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй учраас энэ жилийн эх үүсвэр ингээд дуусаж байгаа юм. Одоо судлагдаж байгаа 96.5 тэрбум төгрөгийн зээлүүд арилжааны банкнууд дээр судлагдаж байна. Төсвийн тодотголын дараа төсөвтөө зохицуулалт хийх замаар хүүгийн хөнгөлөлтийг нь Хүнс, хөдөө аж ахуйн, хөгнө үйлдвэрийн сайдын багцад зохицуулалт хийх замаар эх үүсвэр гаргахаар ажиллаж байна. Тэгээд өнөөдөр арилжааны банкнууд дээр гэрээнийхээ нэмэлт, өөрчлөлтийг хийгээд зээл хэвийн үргэлжлээд явна.

Ер нь цаашидаа энэ хоршооны энэ хэрэгжилт өөрөө 14 зүйл дээр энэ зээл зарцуулагдах ёстой. Эргээд энэ хүнсний хөтөлбөр, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний Цагаан алт хөтөлбөрийн үндэс суурь болох учраас хяналтыг сайжруулах шаардлагатай байгаа. Арилжааны банкнууд дээр үнэхээр зориулалтын дагуу ашиглагдаж байна уу, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна уу гэдэг дээр үнэлэлт, дүгнэлт өгөх, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтраад хяналт,

гүйцэтгэл дээр нь бас хяналт тавих ийм зайлшгүй шаардлага байгаа гэдгийг бас хэлье.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ажлын хэсгийн гишүүддээ бас.

Хөдөө аж ахуйн салбар, байгаль орчны салбарын 2023 оны бас энэ ажлуудыг бас тодорхой дүгнэж байна. Сүүлийн жилүүдэд манай бас хөдөө аж ахуйн салбарт улсын төсвийн болон гадаадын бас зээл, тусламжаар хийгдэж байгаа энэ хувь, хэмжээ бол нэлээдгүй бага байсан. Харин сүүлд энэ Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх болон бас Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санаачлан хэрэгжүүлсэн энэ 3 том төслийн хүрээнд нэлээн бас нэмэгдээд ингээд явж байгаа юм. Тэгээд ер нь хөдөө аж ахуйн салбарын тухай энэ асуудлыг нэлээн сайн задалж хэдүүлээ бас ярих учиртай.

2023 оны хувьд бас яг энэ эдийн засгийн өсөлт салбар салбараар нь гаргаж байгаа Жавхлан сайдаас би бас тодруулъя. Жавхлан сайд аа салбар салбараар нь эдийн засгийн өсөлтийг бас ингээд гаргаад байгаа 2022 онд 9 хувийн бууралттай гэдэг байдлаар гарсан. 23 оны сүүлээр 30 орчим хувьд хувьтай бас гараад байх шиг байна.

Гэхдээ энэ дээр гол нөлөөлж байгаа нь тэр малын тоо толгойтой холбогдолтой асуудал, хорогдолтой холбогдолтой асуудал байгаад байх юм. Гэтэл 2023 онд хөдөө аж аж ахуйн салбарын экспорт 73 хувь хүрсэн байгаа юм. Импорт 12 хувиар буурсан байгаа. Махны экспортоо бид нар 5 дахин нэмэгдүүлсэн байгаа. Улаан буудайн үйлдвэрлэл бас түүхэн дэх хамгийн их бас хэмжээгээр бид нар хураасан. Дахиад хүнсний ногооны дотоодын хэрэгцээгээ бид нар 85 хувь хангадаг болсон гээд яг ингээд салбарын голлох үзүүлэлтүүдийг

харахаар их өндөр өсөлттэй. Одоо яг тодорхой зорилгынхоо хүрээнд бас хийж байгаа ийм ажлууд нь үр дүнтэй юм шиг харагдаад яг салбар салбараар нь гаргаад эдийн засгийн өсөлтөөр нь ингээд дүгнэхээр хамгийн муу салбар болж харагдаад ингээд байх юм. Тэгэхээр энэ бас шалгуур үзүүлэлт болон түүнтэй холбогдолтой юман дээр яг яаж явдаг юм бэ? Цаашидаа энэ 3 хөтөлбөр үргэлжлээд явахаар байна лээ. Тэгээд энэ хөтөлбөртэй холбогдолтой саяын асуултуудад сая хариултаа авчхилаа. Үргэлжлээд явна гэдэг хариултыг бас Төрийн нарийн бичгийн дарга маань бас өгч байна. Энийг л гол шахаад байгаа юм.

Дахиад дээрээс нь яг энэ манай салбарын хамгийн гол суурь асуудал энэ 3 том хөтөлбөр явах газар тариалан, мал аж ахуй, экспортоо нэмэгдүүлэх хамгийн суурь асуудал бол мал эмнэлгийн асуудал байгаа. Мал эмнэлгийн үйл ажиллагааны төлбөрийг 20 гаруй тэрбум төгрөг байсныг 50, 60 болгож нэмэгдүүлсэн. Одоо энэ хүрэлцээтэй байна уу? Яг бид нарын нөгөө Дэлхийн мал эмнэлгийн байгууллагын энэ зорилтдоо хүрэхийн тулд энэ 2023 онд явуулсан үйл ажиллагаа хэрэг үр дүнтэй байсан бэ? Энийг ер нь цаашидаа яах вэ гэдэг чиглэлээр бас асууя.

2023 онд бас хийгдсэн бас нэг чухал зүйл нь манай харьяа байгууллагууд бие даасан корпорацын байдал руу шилжсэн. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн корпорац сан байж байгаад өөрсдөө ингээд бас бие даасан корпорац болсноороо ажлын үйл ажиллагаа ямаршуу болсон бэ? Нөгөө 20, 30 жил бас зээлээ төлөхгүй байгаа энэ зээлдэгч нарын бас эргэн төлөлт ямар байсан бэ гэдэгтэй холбогдолтой.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн яам 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Ганхүлэг сайдын асуултад хариулъя. Хөдөө аж ахуйн салбартай холбоотой салбарын өсөлт гээд ингээд аваад үзэхээр 22, 23 онд

салбарын үйлдвэрлэлийн бодит өсөлтийг хасах хувьтай гэж статистик Үндэсний статистикийн газрын мэдээн дээр оруулсан байгаа. Тэгээд энэ нь өөрөө юутай холбоотой вэ гэхээр цэвэр малын тоо толгой буурсантай холбоотой ийм дүн ийм үзүүлэлтүүд байгаад байгаа. Ялангуяа бид нар 23 оны жилийн эцэст бид нар 64.7 сая толгой мал тоолуулсан. Өмнөх жилүүдээс бид нар даруй 20 хувиар малын тоо толгой ингээд буурсан ийм үзүүлэлттэй. Тэгээд энэ агуулгаараа зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бодит өсөлт гэдгээрээ мал аж ахуйн салбар дээр гарчихсан дүн юм билээ. Эргээд бид нар энэ дээр Статистикийн газрынхантай уулзсан. Яг эдийн засгийн бодит өсөлтөөрөө гэдэг дээр яг таны хэлсэн дүнгүүд ялангуяа хүнсний боловсруулах үйлдвэрлэл дээр л гээд л тэгэхэд борлуулалтын хувь хэмжээ гээд тэгэхэд өмнөх оныхоосоо 23 оны гүйцэтгэл 2.1 их наяд төгрөгийн өсөлттэй. Зөвхөн хүнсний хөтөлбөр Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хэрэгжилттэй холбоотой 19 нэр төрлийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн гээд энэ агуулгаараа аваад үзэхээр импортыг бид нар 13-аас 4 хувийг бид нар бууруулж чадсан юм байна лээ. Жилдээ 1 тэрбум ам.долларын хүнсний бүтээгдэхүүн импортолдог байсан бол бид нар 850 сая долларын хүнсний бүтээгдэхүүнийг импортолсон ийм дүнтэй. Тэгэхээр энэ эдийн засгийн агуулга, эдийн засгийн бодит өсөлт гэдэг агуулгаараа өсөлттэй байгаа гэдгийг хэлье.

Мал эмнэлгийн салбар дээр 2017 онд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдаж, энэ бүтэц, тогтолцоог сайжруулсны үр дүнд бас энэ мал, махны экспорт бас нэмэгдсэн. Мал эрүүлжүүлэх малаа олон улсын хорио цээртэй гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг нэлээн сайн хийж чадсан гэж ингэж үзэж үзэж байгаа. Нийтдээ бид нар 60-аад тэрбум төгрөг 59.4 тэрбум төгрөгийг улсын төсөв дээр суулгаж энэ чиглэлээрээ малын эм бэлдмэл, вакцин

худалдан авах, вакцин, тарилгын хөлс үйлчилгээг нэмэгдүүлэх, орон нутагт тарилга вакцин хийх нөөц бололцоог бүрдүүлэх, мал, амьтны гоц халдварт өвчнүүдийн дуудлага үйлчилгээ, тандалт, баталгаажуулалтын ажлуудыг хийх, олон улсын мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад өвчингүй тайван бүсийн статусаа баталгаажуулах гээд тодорхой өвчтөнүүдээрээ баталгаажуулах ажлуудыг зохион байгуулж ажилласан.

Тэгээд энэний үр дүнд бид нар өнгөрсөн 23 онд мал, махны экспортыг хамгийн өндөр дүнд 320-иод сая долларын орлогыг эндээс ингэж олсон гэж ингэж үзэж байгаа. Цаашидаа энэ мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага байгаа. Энэ дотроо “Биокомбинат”-ын өргөтгөл шинэчлэлийн ажлууд, тарилга вакцинаа дотооддоо үйлдвэрлэх асуудлууд бас нэлээн тулгамдаж байгаа юм. Тэгээд 25 оны төсөв дээрээ бас тодорхой саналуудыг бид нар боловсруулаад хүргүүлж байгаа гэдгээ бас хэлье.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Корпорацийнхаа тухай бас мэдээллээ бас өгчих нь зөв байх. Өнгөрсөн оны бас гол ажлуудын нэг байсан. Дахиад дээрээс нь Эрдэнэсайхан дарга хариулах уу? Энэ Шинэ хоршоогийн зохион байгуулалтыг Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар дээр бас очиж ажиллахаар болж байгаа юм байна лээ. Тэгэхээр хэчнээн хүний бүрэлдэхүүнтэй, ямар зохион байгуулалттай, яаж явахаар төлөвлөж байгаа тухай, тэгээд энэ зээл ахиад банкнуудтай бас дахин хэлэлцээр хийгээд үргэлжлээд явна гэж ойлголоо. Тэгэхээр одоо энийг бас идэвхжүүлэх, зохион байгуулалтад оруулах, хүлээгдсэн байгаа бас хошоодуудыг идэвхжүүлэх чиглэл дээр маш шуурхай арга хэмжээг аваад ажиллах хэрэгтэй болох нь. Тэгэхээр энэ ирэх оныг хүлээлгүйгээр 2024 ондоо

үргэлжлүүлэх ажлын төлөвлөгөө юмнуудаа бас ямар түвшинд байгаа вэ гэдэг талаар мэдээлэл авъя.

Байгаль орчны яамнаас бас дэлхий нийтийн өмнө бид нар Тэрбум мод гээд хөдөлгөөн өрнүүлнэ, бас нэлээн бас том давлагаа болно гээд ингээд зарлачихсан байгаа. 2023 оны үр дүн бас энэ дээр ямар байсан бэ гэдэг талаар бас мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: Корпорацийн талаар Цогтсаран хариулаарай. 4 номер. Дараа нь Эрдэнэсайхан хариулах юм байна тээ.

Б.Цогтсаран: Ганхүлэг гишүүний асуултад нэмэлт тодруулга хийе. Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК бол 2023 оны 7 сард албан ёсоор Монгол Улсын Их Хурлын чуулганаар соёрхон баталж, ТӨК тогтсон. Өмнөх хугацаандаа 1999 оноос сан “Буудайн сан” нэртэй анх байгуулагдаж байгаад 24 он хүртэл энэ үйл ажиллагаа явуулж байсан ийм байгууллага байгаа юм.

Сангийн маань гол өнгөрсөн хугацаанд олгосон төрөөс өгсөн дэмжлэгүүдийн маань буцаан төлөлтийн асуудал ерөнхийдөө үеийн үед бас нэлээн хөндөгдөж ирсэн асуудал байгаа. Өнөөдрийн байдлаар 100 гаруй тэрбумын хугацаа хэтэрсэн өр, авлага байдаг. Энэ сан байхдаа бас тодорхой хуулийн чиг үүргийн хувьд бас заалтуудтай зөрчилдөөд байдаг учраас бас төлбөр барагдуулалт нэлээн удааширч ирсэн. Компани болсноороо бид бүхэн өөрсдийнхөө бололцоо.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж яриулъя. 4 номер.

Б.Цогтсаран: Үүнтэй уялдуулаад өр, авлагыг барагдуулах ажил дээр нэлээн идэвхлэн санаачилга гарган ажиллаж ирлээ. Үүнд нэгдүгээрт нь Монгол Улсын Засгийн газраас Цахим, хөгжлийн яамны харьяа shil.mn-д албан ёсоор нийт харилцагчийн мэдээллийг ил тод, хамгийн түрүүнд бас болгож бас

төлбөр барагдуулахад нэлээн дөхөм болсон ийм ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Хур системд албан ёсоор эрхээ аваад бас тодорхой хуулийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Ингэснээрээ бас тухайн харилцагч маань нэр усаа өөрчлөн компанийн мэдээллээ солиод дахин зээл авах боломжгүй болох нөхцөлийг бас бүрдүүлж байна. Мөн дараачийн зээл олголтдоо бас системийн үйлчилгээг ашиглаж дэмжлэг зээлүүдийг олгож ирж байна. Мөн дээрх бүх харилцагчийг бас Монголбанканд албан ёсны мэдээллийн санд нь бүртгүүлж албажууллаа. Ингэснээр бас дахин хугацаа хэтэрсэн зээлтэй аж ахуйн нэгжүүд маань .../минут дуусав./

Б.Бейсен: Эрдэнэсайхан хариулъя.

Я.Эрдэнэсайхан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Эрдэнэсайхан. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Шинэ сэргэлтийн хурдасгуур төвөөс энэ хоршоо хариуцсан 12 хүнийг 14 хоногийн өмнө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Жижиг, дунд үйлдвэрлэлийн газарт шилжүүлэхээр болсон. Тогтоол өнөөдрөөс албажиж байна. Ингээд зохион байгуулалтын ажлуудыг хийнэ. Мэдээж энэ хүрээнд маш олон ажлуудыг хийнэ гэдэг хэлж байгаа таны саналтай санал нэг байгаа.

Жишээ нь, энэ хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүнийг хоршоогоор дамжуулаад Хөдөө аж ахуйн биржээр, тэгээд үндэсний үйлдвэр экспортод гаргахад бол энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний мөнгө болгож хувиргахад хамгийн гол суурь бүтэц бол хоршоо байгаа.

Тэгэхээр бид нар бас олон, 30 жил ингээд амь амиа бодсон энэ системээр явж байгаад хөдөө аж ахуйн энэ бүтээгдэхүүнийг мөнгө болгох энэ урсгал дээр энэ бүтэц байхгүй байсан учраас ингээд хийгдэхгүй ченжийн тогтолцоогоор явчихсан.

Б.Бейсен: Гүйцээж хариулъя 4 номер.

Я.Эрдэнэсайхан: Энэний гарцыг ингээд гаргаад хоршоо гээд ингээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр малчдаа сургаж, хорших энэ бүтцийг нь хөгжүүлэх тэгээд зөвлөх үйлчилгээгээр хангахаас гадна үндэсний үйлдвэрүүдэд энийг нийлүүлэх энэ бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг нь хийх, орон нутагт нь тордолтын цэгийг байгуулах гэх мэтчилэн энэ олон ажлуудыг бол үлдсэн хугацаанд хийх ийм нэн шаардлагатай байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя. Байгаль орчны яам 3 номер хариулъя.

Э.Баттулга: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэрбум модны ажил бол идэвхтэй явж байгаа. 2023 онд 12.9 тэрбум төгрөгийн төсөв тавигдаж байсан бол ойн салбарт 2024 онд 45.1 тэрбум болж өссөн. Энэ жил бид нар 60 дахь сая модныхоо тарьц суулгацыг, ойжуулалтынхаа ажлыг хийх гээд бэлтгэл хангаад явж байна.

Өнгөрсөн хугацаанд бол энэ хортон, зөвхөн ойжуулалтын ажил биш хортон шавжстай тэмцэх энэ техникийн чадавхаа нэмэгдүүлэх, түймэртэй тэмцэх, агро ойн аж ахуйг иж бүрэн утгаар нь хөгжүүлэх гэх мэтчилэн энэ олон талт ажлууд руу хандаж явж байгаа.

2025 оны хувьд төлөвлөх гол ажил бол бид нар энэ 1 га талбайн ойжуулалтын норматив зардал, мөн таримал ойг улсын ойн санд хүлээн, худалдан авах ийм хуулийн зохицуулалт байдаг. Ойн тухай хуульд заасан. Энийгээ нэмэгдүүлэх замаар бас энэ ойжуулалтын ажилд оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгж мэргэжлийн байгууллагуудын идэвх оролцоо.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Сайн байцгаана уу? Би аудитын тайлантай холбоотойгоор хэдэн асуулт асууя. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж баталгаажуулаагүй, өмч хамгаалах комисс байгуулаагүй, зарим хөрөнгийг тооллогод хамруулаагүй, биетээр оршин байхгүй 803 тэрбум төгрөгөөс хөдөө аж ахуйн сайдын 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө байна. Энэ хөрөнгийг Сангийн яам яаж баталгаажуулж ажиллах вэ? Ер нь ямар арга хэмжээ авах вэ? Цаашилаад анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 700 сая төгрөг байна. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд бас сайдаас 7.5 тэрбум төгрөгийг бас байршуулсан байна. Энэ мөнгөн хөрөнгийг ер нь хэрхэн барагдуулахаар ажиллаж байгаа вэ гэдэг дээр Сангийн яамнаас асуумаар байна. Мөн бас энэ Хөдөө аж ахуй яам маш их хэмжээний төсөл, хөтөлбөр барилга, байшин худалдан авалтууд хийхээр төсөвт 24 онд бас тусгагдсан байгаа. Гэтэл өнгөрсөн гүйцэтгэлээр авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шүүхийн шийдвэр хэрэгжээгүй, тайлагнаагүй, авлага тайлагнаагүй гэсэн нийтдээ бараг 116 тэрбум төгрөг байна.

Тэгээд энэ авлагыг хэрхэн барагдуулах, ямар төлөвлөгөөтэй ажиллах юм бэ гэдэг дээр бас яагаад гэхлээр дараа дараагийн төслүүд дээр дахиад ийм авлага үүссэн ийм хариуцлагагүй, актаар баталгаажуулаагүй иймэрхүү тайлагнаагүй асуудлууд үүсэх вий гэдэг дээр бас анхаарч харж байна.

Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалттай холбоотой энэ хөрөнгө оруулалт 2 жилийн хугацаанд 2022-24 оны хугацаанд 24 тэрбум төгрөгийг зарцуулж байгаа

юм байна. Тэгэхлээр энэ жил 5.6 тэрбум төгрөг зарцуулахаар тэгэхээр одоо энэний гүйцэтгэл ямар шатдаа явж байгаа юм бэ? Ер нь бол энэ онд ингээд дуусна гэж төлөвлөгдөж байгаа юм уу? Ер нь яг энэ 24 тэрбум төгрөгийг зарцуулаад, одоо яг гүйцэтгэл нь ямар шатдаа явж байгаа юм бэ гэсэн асуултыг Хөдөө аж ахуйн яамнаас асууя.

Б.Бейсен: 5 номер хариулъя. Сангийн сайд хариулах юм уу эхлээд? Хөдөө аж ахуй. Сангийн сайд эхлээд хариулъя.

Б.Жавхлан: Мандухай гишүүний асуултад хариулъя. Тэр өмчийн бүртгэлтэй холбоотой асуудал ярилаа. Энэ нөгөө Төрийн өмчийн бодлого зохицуулалт газрын 100 хувь хариуцдаг ажил байхгүй юу. Хөрөнгийн бүртгэл. Уг нь тэднийхээр хариулах ёстой. Тийм, манай дээр энэ талаар ерөөсөө ямар ч асуудал байхгүй.

Б.Бейсен: 4 номер Аудитынхан.

Ц.Наранчимэг: Мандухай гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хязгаарлалттай санал, дүгнэлт өгөх үндэслэл Хөдөө аж ахуйн корпорац ТӨХК дээр гарсан энэ саяын гишүүний дурдсан аудитын зөрчилтэй холбоотой асуудлууд байгаа. Бид энэ тооллого, тооцоо хийхгүй байгаа, авлага, өглөгөө барагдуулахгүй байгаа гээд санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын маань гол үндэслэл санхүүгийн тайлангийн 4 тайлан үнэн, зөв хэсэгт баталгаажуулж аудит хийж хүргүүлдэг. Төрийн аудитын тухай хуулийн стандартад төрийн аудитын байгууллагын энэ баталгаажуулсан 4 тайлан дээр Улсын Их Хурал болон бусад хэрэглэгчид өөрсдөө дүгнэлтээ гаргах гол тайлангийн маань зорилго энэ зорилго байгаад байгаа юм. Тэгэхээр Төсвийн тухай хуульд 2023 оны 7 дугаар сард

өөрчлөлт ороод төрийн аудит.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулчихъя.

Ц.Наранчимэг: Төрийн аудитын байгууллагаас гаргасан энэ алдаа зөрчлийг арилгах тал дээр тайланг хүлээж аваад 30 хоногийн дотор хэрхэн, яаж энэ ажлыг сайжруулах тал дээр төлөвлөгөө гаргаж ирүүлэх ийм хуулийн шинэ зохицуулалттай болсон. 30 хоногийн дотор төлөвлөгөө гаргаж ирүүлээгүй бол тухайн төсөв захирагчдад хариуцлага тооцно.

Бид санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн өгсөн. Энэ аудитаар гаргасан энэ шийдлийнхээ биелэлтийг 9 дүгээр сарын 5-наас завсрын аудит буюу давхар энэ өмнө нь аудитаар гарсан энэ илрүүлэлтээ шалгадаг давтан аудитаараа энэ зөрчлийнхөө биелэлтийг дүгнэдэг ийм Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журамтай. Энэ журмын хүрээнд бид 9 дүгээр сард одоо энэнийхээ биелэлтийг шалгана.

Энэ хуулийн зохицуулалттай холбогдуулаад төсөв захирагч нар 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад төлөвлөгөөгөө ирүүлж байгаа. Энэ төлөвлөгөөний биелэлт хэрхэн.../минут дуусав./

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн яамныхан. 5 номер.

Т.Жамбалцэрэн: Мандхай гишүүний асуултад хариулъя. Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн дэд бүтэцтэй холбоотой энэ өөрөө 35.9 тэрбум төгрөгийн нийт санхүүжилттэй. Үндсэндээ 21.2 тэрбумын санхүүжилт нь хийгдсэн. Одоо төслийн ажил 80 хувьтай, суурь дэд бүтцийн ажлууд энд нь ариутгах татуурга, цэвэр усны байгууламж, цэвэрлэх байгууламж, зам талбай, цахилгаан, дэд бүтэц гээд ингээд үндсэн дэд бүтцийн ажлууд нь хийгдэнэ. Төр өөрөө энэ үйлдвэр технологийн

паркуудтай дэд бүтцүүдийг нь хийж өгнө. Эргээд хувийн хэвшилүүд энэ дээр үйлдвэр аж ахуйн газруудаа байгуулаад ингээд ажиллах ийм зохицуулалттай явж байгаа. Тэгээд төсөв нь өөрөө 25 оныг дамжаад орж байгаа учраас бид нар ажлыг нь шахаад энэ ондоо дэд бүтцийнх нь ажлыг бүрэн дуусгачихъя гэсэн ийм төлөвлөгөөтэй ажилладаг. Одоо 80 хувийн гүйцэтгэлтэй ингээд явж байгаа.

Хүнс, хөдөө аж ахуйн, хөгнө үйлдвэрийн салбар өөрөө улсын нэгдсэн төсөв.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулъя. 5 номер.

Т.Жамбалцэрэн: Төсөвт эзэлж байгаа хувь хэмжээ нь өөрөө нийт төсвийн 2.9 хувь л байдаг юм. Тэгээд энэ 23 оны төсөв дээр бид нар 90.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Энэний 50 хувь нь ерөөсөө татаас урамшуулах хүүгийн хөнгөлөлтүүд. Тэгээд үлдсэн нь бол урсгал зардлууд болдог. Хөрөнгө оруулалт нь 7, 8 хувийн хөрөнгө оруулалттай байдаг. Энэ дээр олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгүүд нэмэгдээд тооцогдохдог учраас тийм олон төсөл, хөрөнгө оруулалтууд харьцангуй бага.

Саяын тэр ярьж байгаа тэр 160-аад тэрбум төгрөгийн өр, авлага ингээд явж байна гэдэг маань энэ өөрөө 2006 оноос хойш өнөөдрийг хүртэл явж ирсэн өр хуримтлагдсан өр, авлагууд. Энэний дийлэнх нь 110-аад тэрбум нь манай Хөдөө аж ахуйн корпорац буюу хуучин Буудайн сан, Тариалан эргэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан Хөдөө аж ахуйн корпорац болоод одоо ингээд энэ үндсэндээ бараг 20-иод жилийн хуримтлагдсан өр, авлагын ийм тооцоолол явж байгаа. Тэгээд энийг задаргаануудыг нь манай корпорацын захирал бас.

Б.Бейсен: Мандухай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Монголбанкнаас тогтоосон зохицоо, харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй банканд яг сайдын багцаас 7.5 тэрбум төгрөг байршуулсан байгаад байгаа. Энэ мөнгөн хөрөнгийг ерөнхийдөө яаж барагдуулах вэ? Энэ дээр хэн хариулт өгөх байсан?

Б.Бейсен: 4, 5 номер хариулъя.

Т.Жамбалцэрэн: Энэ Азийн хөгжлийн санхүүжилттэй хөдөө аж ахуй Хөдөөгийн хөгжил төсөлтэй холбоотой санхүүжилт. Тэгээд энэ хөрөнгийг хөдөө аж ахуйн сайдын багц дээр байхдаа байршуулаагүй юм. Энэ 2020 онд энэ төсөл хэрэгжээд үндсэндээ төслийн хэрэгжилт 90 гаруй хувьтай, гүйцэтгэлтэй төсөл Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад шилжиж ирсэн юм. Тэгэхэд энэ хөрөнгүүд тухайн үеийн Сангийн сайдын шийдвэрээр төслүүд арилжааны банкнууд дээр хөрөнгүүд байршигдсан байсан ийм төслүүд байгаад байгаа юм. Тэгээд энэ чиглэлээр Үндэсний хөрөнгө оруулалтын банкин дээр, Чингис хаан банкин дээр, Капитал банкин дээр гэдэг юм уу хуримтлагдсан өр, авлагууд байгаа. Тэгээд энийг шүүхийн шийдвэрүүд нь гараад бид нар эрх хүлээн авагчтай нь холбогдоод тодорхой хөрөнгүүдийг шилжүүлж авах чиглэлээр ингээж ажиллаж байгаа.

Гэхдээ хөрөнгийг байршуулсан шийдвэрүүд нь 20 оноос өмнөх буюу Сангийн сайдын шийдвэрээр байршиж байсан ийм шийдвэрүүд байгаа.

Б.Бейсен: Аудитынхан хариулах гэж байна уу? Санжаадорж дарга хариулах уу? Наранчимэг дарга 4 номер.

Ц.Наранчимэг: Мандхай гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Бид энэ хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг төрийн аудитын байгууллага хаагдаад дууссан үед гүйцэтгэлийн аудит хийлгэж энэ төсөл, хөтөлбөр хэр зэрэг үр дүнтэй явчхав

гэдэг дээр анхаарах зайлиггүй шаардлага байна гэдгийг төрийн аудитын байгууллагаас удаа дараа зөвлөж байгаа.

Энэ Хөдөө аж ахуйн яамны харьяа энэ төсөл дээр байгаа энэ байрилын мөнгийг бид энэ найдваргүй гэсэн эрсдэлтэй гэсэн банканд байришиж байгаа энэ мөнгийг ямар нэгэн хэлбэрээр авч улсыг хохиролгүй болгохыг аудитын байгууллагаас зөвлөж байгаа. Түрүүн тэр авлагатай холбоотой энэ Хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын хариулж байгаа энэ олон жил болсон авлагуудын талаар аудитын байгууллагаас удаа дараа албан шаардлага өгөөд үнэхээр зарим авлагыг ажил маш сайн зохион байгуулсан ч гэсэн барагдуулах боломжгүй авлагууд байгаад байгаа. Аудитын байгууллагаас.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж хариулчихъя.

Ц.Наранчимэг: Энэ жилийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаараа бид энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой төсөвт байгууллагуудад зөвлөмж буюу албан шаардлага өгөхдөө хувь зааж өгч байгаа. Энийг хэрэгжүүлэхийн тулд. Та нар дараа жилийн аудит ороход тэдэн хувийг нь заавал ямар нэгэн арга хэмжээ авч, энийг биелэлтийг хангасан бай гээд. Саяын 101.8 тэрбум төгрөгийн Хөдөө аж ахуйн корпорац дээр байгаа баталгаажуулаагүй авлагыг бид нар 30-аас доошгүй хувь дээр нь тодорхой үр дүнд хүрсэн ажил зохион байгуул гэсэн албан шаардлага өгсөн. Ингэж байж аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмж, албан шаардлага үр дүнтэй болох юм байна гэж ингэж үзээд энэ жилээс тодорхой хувь зааж өгөөд дараа нь аудит дүгнэхдээ тэр хувьд хүрсэн ажлуудыг хийгдээгүй бол хуульд заасан арга хэмжээг аваад явна гэсэн ийм зохицуулалттай болсон.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлантай холбогдуулан үг хийдэг гишүүд байна уу?

Идэрбат гишүүнээр тасаллаа.
Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Бас сүүлийн хэд хэдэн Байнгын хороон дээр бас ярьж хэлсэн ажлууд бас нэг талдаа гарч байгаад талархалтай байгаа юм. Мөн орон нутагт Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдолтой маш их хүсэлтүүд бас хүлээгдсэн байдалтай бас байгаа. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан, манай Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрынхан энэ асуудал дээрээ маш сайн анхаарлаа хандуулаад хэдүүлээ тодорхой шийдлүүд бас гарсантай холбогдолтой малчдыг бас энэ хоршоологчдыг бас чирэгдүүлэхгүйгээр их сайхан зохион байгуулалтад ороод ажиллая. Түүнээс үргэлжлүүлэн явуулах асуудал хамгийн эхний асуудал байгаа.

Хоёр дахь нь өмнө нь авчихсан байгаа 13 мянга орчим энэ малчид маань ямар байдлаар бас үйл ажиллагаагаа явуулж байна вэ, хоршоонууд маань яаж байна вэ гэдэг дээр та бүхэн маань маш хурдан шилжүүлж аваад тэгээд зохион байгуулалт жижигхэн тайлан, танилцуулга юмнууд бас бэлдээд тэгээд Байнгын хороогоороо бас оруулах ийм бас саналтай байна. Тэгээд энэ дээрээ дүгнэлт хийгээд зориулалт нь ямар ямар чиглэлээр хамгийн их гарсан байна, тэгээд яаж ажиллаж байна гэдэг дээрээ бүгдээрээ анализ хийе.

Тэгээд энэ чиглэлээр бас Эрдэнэсайхан дарга бас өөрөө санаачилга гаргаад нэлээн сайн бас идэвхтэй ажиллаарай гэдэг энэ саналыг бас хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн үг хэлье.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Би хоёр, гурван юм байгаа юм. Зарим нь ч

давхцаж байх шиг байна. Энэ хоршооны зээл гээд ингээд 2 эх үүсвэр яваад байна даа. Түрүүнд бас Мэндсайхан гишүүн хэлсэн. Ингээд тэр чинь хоршоо байхгүй үед сумын Засаг даргын Тамгын газар дээр бүр үүх түүхийг нь ярих юм бол нөгөө Жижиг, дунд бизнесийг дэмжих сангийн зээл гэж наадах чинь улсын хэмжээнд 330, 40 тэрбум төгрөг тарчихсан тэр эх үүсвэр дээр одоо хоршооны зээл явж байгаа. Сумаар дамжаад байгаа хоршоо яриад байгаа шүү дээ. Тэгээд энийг энэ хоршоо гээд нэг л зээлээ олгодог ийм систем рүүгээ орохгүй бол давхар давхар хоршоо ярьсан л юм болж хувираад байгаа юм даа. Тэгээд суман дээр тарчихсан тэр зээлийн эх үүсвэрийг нэлээн хумьж авбал өнөөдөр бидний дутагдаад байгаа хоршооны эх үүсвэрүүд ч гарахыг үгүйсгэхээргүй тийм л нөхцөл байдалд байгаа. Тэрийг олгож байгаа сумын Засаг даргын Тамгын газрын ажилчид маш хэцүү байдалд байдаг юм шүү дээ. Тэр чинь банкны зээлийн эдийн засагчийн ажил хийж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт зээлээ өгөхгүй хүмүүсийн араас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажил хийнэ. Тэгээд яг тэр ажлыг хийж байгаа хүний албан тушаалын тодорхойлолтод зээлийн эдийн засагчийн мэдлэг, эсвэл тэр араас нь явах хуульчийн мэдлэг эд нар шаардагдахгүй ажил хийж байгаа хүн шүү дээ. Тэгэхээр ингээд ийм замбараагүй юмыг бол цэгцлээд нэг юм руугаа оруулчихвал зорилго маань ч биелэх юм, тэнд байгаа төрийн албан хаагчдын нуруу ч амархан юм.

Одоо сумд эд нар бол жижигхэн шүү дээ. Нэг нэгэндээ зээл олгоно гэдэг бол тэгээд тойруугаараа хамаатандаа л олгочих гээд байгаа ийм л зүйлүүд ороогдчих гээд байдаг юм даа. Тэгэхээр энийг би бас чуулганы хуралдаан дээр ч ярьж байсан. Сая Мэндсайхан гишүүн бас ярьж байна. Тэгэхээр энэ Жижиг, дунд бизнесийн сангаас эхлэлтэй явсан энэ зээлийн асуудлыг нэлээн нэгтгэх

талын юм бодвол яасан юм бэ гэж нэгдүгээрт санал байгаа юм.

Хоёрдугаарт, энэ хөдөө аж ахуйн салбар дээр хэрэгжиж байгаа дарааллаар нь яривал Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо гэсэн энэ 3 хөтөлбөр бол ёстой яагаад ч салж болохгүй ийм хөтөлбөр байлаа шүү. Одоо ингээд Хэрэг эрхлэх газраас Хурдасгуур төв дээр байсан энэ хүмүүс Хөдөө аж ахуйн яамны Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар очиж байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ хүмүүсийн үйл ажиллагааны чиглэл ямархуу байх вэ гэдэг дээрээ бас та бүхэн минь бас анхаараарай гэж би бас зориуд хэлэх гэж байгаа юм.

Яагаад гэвэл энэ 4 жил бид бүхний бас магадгүй энэ Байнгын хороон дээр хөдөө аж ахуйн салбарын яригдах том төслүүдийг гэвэл энэ гурвыгаа л бид хэлэх байх. Тийм учраас энэ Цагаан алт, энэ Шинэ хоршоо, энэ Хүнсний хувьсгал гэсэн энэ 3 зүйлийг, хөтөлбөрийг Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн тэр нөгөө зээл олголттой, эд нар холбоод хутгаад явчихвал бас саармагжих вий л гэсэн ийм л бодлого байна.

Тэгэхээр яамны тэр дотор бүтцүүд байгаа тэрэнтэйгээ яаж уялдуулах юм тэрийгээ бас их зөв бодоорой гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам яг ингээд ийм яамны нэр ус солигдож байгаа, чиг үүрэг солигдож байгаа цаг хугацаанд бид нар энийг ярьж байгаа учраас хуучин Байгаль орчны яаман дээр байсан аялал жуулчлалтай холбоотой энэ хөрөнгө оруулалтын асуудлууд 2025 оны төсөв дээр тусгаж эхэлсэн ажлуудыг дуусгах ийм үндсэн чиглэлийг би 25 ондоо баримталж байгаа болов уу. Тэрийг тухайн яам төсөв боловсруулах шатад та хэд чинь солигдоогүй байлаа шүү дээ. Тэрийгээ барьж байгаа болов уу

л гэж ингээж бодож байгаа. Одоо төсөв ороод ирэхээр энэ талаар нэлээн тодорхой болох байх. Он удаан жил дамждаг, дамжихынхаа хэрээр төсөвт өртөг нь нэмэгддэг, тэрнээсээ болоод гүйцэтгэл дээр хүндрэлүүд гардаг ийм зүйлийг энэ төсвийн жилээр бас эцэслэхвэл гэсэн ийм л бодолтой байгаа юм. Тэгэхээр Байгаль орчных тухайн хүмүүс нь шилжчихсэн байгаа юм.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайл нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндсайхан Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

15.57 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР